

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Код: СТ-13/ 213

**ХҮҮХДИЙН ӨМЧЛӨЛ, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР
ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

(Харьцуулсан судалгаа)

Гүйцэтгэсэн судлаач:

**Р.ХАТАНБААТАР
А.ПАГМА
Д.ЖИВГААГҮНСЭЛ
Г.ГЭРЛЭЭ**

**Улаанбаатар
2013 он**

УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Д.Оюунхоролын захиалгаар “Хүүхдийн өмчлөл, эд хөрөнгийн эрхийг хамгаалах талаар гадаадын зарим орны эрх зүйн орчин ” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачид гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Хүүхдийн өмчлөл, эд хөрөнгийн эрхийг хамгаалах асуудлын эрх зүйн зохицуулалтыг зарим орны тухайлбал, Канад, Швед, Украин, Хятад, Литва, Хонг Конг, Финландын зохих хууль эрх зүйн орчныг судлан жишээн харьцуулан гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Хүүхдийн өмчлөл, эд хөрөнгийн эрхийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Гэрлэлт цуцлах үед хүүхдийн эрх, түүний дотор хүүхдийн өмчлөлийн эрхийг хэрхэн шийдвэрлэдэг талаар харьцуулан судлах,
- Хүүхдийн өвлөх эрхийн талаар дээрхи улсуудын эрх зүйн орчныг судлах,
- Дээрхи орнуудад хүүхдийн өмчлөл, эд хөрөнгийн эрхийг хамгаалах асуудлын эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан дэлгэрэнгүй материал бэлтгэх зэрэг болно.

Судалгааны аргачлал:

-Гадаадын зарим орнуудын Гэр бүлийн хууль, Гэрлэлтийн хууль, Гэр бүл салалтын тухай хууль зэрэг хуулийн холбогдох бүлэг заалт,

-Гадаадын зарим орны Иргэний хуулийн холбогдох заалт,

-Судалгааны материалыг нэгтгэн тайлан бичих зэрэг болно.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р.Хатанбаатар, референт-шинжээч А.Пагма, референт-судлаач Д. Живгаагүнсэл, Г.Гэрлээ нар хийж гүйцэтгэв.

Бүгд Найрамдах Украин улс

1. Гэр бүлийн эрх зүйн харилцааны нэг чухал хэсэг нь эцэг, эх ба хүүхдийн хоорондын өмчийн харилцааны асуудал юм. Гэр бүл бүр гишүүдийнхээ ахуйн болон бусад хэрэгцээг хангахад зориулагдсан тодорхой хэмжээний өмчтэй байдаг.

Украины Гэр бүлийн хуульд эцэг, эх болон хүүхдийн өмчийг тусгаарлан авч үзэх зарчим барьдаг. Уг хуулийн Нэгдүгээр хэсгийн 173 дугаар заалт ёсоор эцэг, эх ба хүүхдүүд (үүнд хамтдаа амьдарч буй хүүхдүүд ч орно) тус тусдаа бие даасан өмчлөгчид байж болно. Энэ нь эцэг, эх ба хүүхдийн хамтран амьдарсан хугацаа болон хэн нэгэнд нь харьяалагдах өмчийг хамтран ашигласан хугацаанаас үл хамааран уг хөрөнгө анхны өмчлөгчдөө харьяалагдана гэсэн үг.

Гэхдээ Гэр бүлийн хуулиар маргаантай өмчийн хувьд эцэг, эхийн өмчлөх эрхийн давуутайг мөн баталгаажуулдаг. Тухайлбал, эцэг, эх ба хамтран амьдардаг бага насны юмуу насанд хүрээгүй хүүхдийн хооронд өмчлөх асуудлаар маргаан гарахад уг өмчийг эцэг, эхийнх нь өмч гэж тооцно. Харин эцэг, эх болон тэдний аль нэг нь хүүхдийнхээ хөгжил, сургалт, хүмүүжилд зориулан авч өгсөн эд зүйлс нь уг хуулийн 174 дүгээр зүйлийн дагуу хүүхдийн өмч байна.

Эцэг, эх нь өөрсдийн хамтын өмч болон тус тусын өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа насанд хүрээгүй хүүхдийнхээ эрх ашгийг заавал харгалзах ёстой. Хүүхдийн өмчийн хувьд бол уг өмчийг захирах асуудлыг эцэг, эх хамтран шийдвэрлэнэ. Эцэг, эх өөрийн хүүхдийн өмчийг насанд хүртэл нь захирна. Эцэг, эх нь хүүхдийн өмчийг захирч дууссаны дараа уг өмч болон орлогыг хүүхдэд буцааж өгөх үүрэгтэй.

2. Украины Гэр бүлийн хуулиар хүүхдийн тэтгэлгийн асуудлыг мөн зохицуулдаг. Хүүхдийн тэтгэлгийн төлбөрийг хүүхэдтэйгээ хамт амьдарч байгаа эхийн юмуу эцгийн нэр дээр хийнэ. Гэр бүлийн хуулийн Нэгдүгээр хэсгийн 179 дүгээр зүйлийн дагуу хүүхдийн тэтгэлэг хүлээн авсан эх юмуу эцэг нь тэтгэлгийг өмчлөх эрхтэй болохоос гадна зөвхөн зориулалтын нь дагуу хүүхдийн хэрэгцээ, сургалт, хөгжилд зориулах үүрэг хүлээнэ. Гэхдээ насанд хүрээгүй хүүхэд тэтгэлгийг захиран зарцуулахад оролцох эрхтэй бөгөөд 14 нас хүрсэн бол хүүхдийн тэтгэлгийг өөрөө биечлэн авч, зарцуулах эрхтэй.

Эцэг, эх ба хүүхдийн эрхийн харилцааны нэг чухал хэсэг нь тэжээн тэтгэх асуудал юм. Эрхийн энэ харилцаагаар нэг тал нь хуулиар тогтоогдсон журмын дагуу нөгөө талаа тэжээн тэтгэх бөгөөд хоёрдахь тал нь энэ үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй. Хүүхэд насанд хүрээгүйн улмаас тодорхой хэмжээний материалын дэмжлэг, хамгаалалт шаардлагатай байдаг онцлогоос үүдэн эцэг, эх нь хүүхдийг насанд хүртэл нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

Хууль тогтоомжоор хүүхдийн тэтгэлгийг төлөх сайн дурын ба албадан гэсэн хоёр хэлбэр бий. Эцэг, эхийн хэн нэгний санаачлагаар, өргөдлийг нь үндэслэн албан байгууллага, тэтгэвэр авах газар болон стипендээс нь суутган тооцож хүүхдийн тэтгэлгийг төлж болно.

Мөн хүүхдийн тэтгэлгийн асуудлыг харилцан тохиролцсны үндсэн дээр шийдвэрлэх боломж байна. Эцэг, эхчүүдэд хүүхдийнхээ хүнс, хувцас, сургалт, чөлөөт цаг болон бусад ахуйн хэрэгцээгээ хангахад шаардагдах мөнгөний хэмжээг өөрсдөө бие даан тохиролцох боломж олгоно. Энэ тохиолдолд Гэр бүлийн хуулийн 93, 189 дүгээр заалтуудын дагуу хүүхдийн тэтгэлэг төлөх тухай гэрээ байгуулна.

Гэр бүлийн хуулиар хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тогтоох хоёр аргыг зөвшөөрдөг:

- 1) Хүүхдийн эцэг юмуу эхийн орлогын тодорхой хэсэг
- 2) Тодорхой мөнгөн дүн.

Гэр бүлийн хуулийн хоёрдугаар хэсгийн 182 дугаар заалт ёсоор нэг хүүхдэд оногдох тэтгэлгийн хэмжээ нь иргэдийн татвар ноогдуулаагүй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байж болохгүй. Хуулиар хүүхдийн тэтгэлгийн дээд хэмжээг тогтоогоогүй.

Гэхдээ шүүхээс хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тогтоохдоо дараах нөхцлүүдийг харгалзан үзнэ:

- 1) Хүүхдийн эрүүл мэндийн болон материаллаг байдал
- 2) Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн эрүүл мэндийн болон материаллаг байдал
- 3) Хүүхдийн тэтгэлэг төлөгч өөр хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхөр, эцэг, эхтэй эсэх
- 4) Гарцаагүй харгалзан үзэх бусад шалтгаан зэрэг болно.

Хүүхдийн тэтгэлгийг мөн эцэг, эх хоёулангаас нь албадан гаргуулах тохиолдол бий, жишээлбэл, тэдний эцэг, эхийн эрхийг хасах нь хүүхдээ тэжээн тэтгэхээс чөлөөлөхгүй.

Гэр бүлийн хуулийн нэгдүгээр хэсгийн 18 дугаар заалтаар 14 нас хүрсэн хүүхэд хүүхдийн тэтгэлэг тогтоолгохоор өөрөө бие даан шүүхэд хандаж болно. Амьдралд зарим үед хүүхэд өвчлөх гэх зэрэг төрөл бүрийн урьдчилан тооцоогүй зардал гардаг. Энэ тохиолдолд гарсан нэмэлт зардлыг шүүхээс тогтоон хүүхдийн тэтгэлэг дээр нэмж гаргуулан авна.

3. Гэр бүл салахад хүүхдийн эрхийг Гэр бүлийн хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хамгаална. Хэрэв гэр бүл салахад хоёр талаас зөвшөөрсөн бөгөөд уг гэр бүл хүүхэдгүй, эсвэл хүүхэд нь 18 нас хүрсэн байвал гэрлэлтийг Иргэний бүртгэлийн байгууллагаас цуцлана. Харин гэр бүл насанд хүрээгүй хүүхэдтэй бол гэрлэлтийг шүүхээр цуцлана. Шүүх гэрлэлтийг цуцлах асуудлыг авч үзэж, шийдвэр гаргахдаа насанд хүрээгүй хүүхдийн эрх зөрчигдөхгүй байх нөхцлийг хангах ёстой.

Гэр бүлд хамтран олсон бүх хөрөнгийг гэр бүл цуцлахад эхнэр, нөхөр тэнцүү

хуваан авах боловч шүүхээс хүүхдийн эрх ашгийг харгалзан хүүхдээ өөр дээрээ авч үлдэж буй эх юмуу эцэгт хөрөнгөөс илүү хувь ноогдуулдаг.

Украин улсын Гэр бүлийн хуулиас:

Зүйл 109. Хүүхэдтэй эхнэр, нөхрийн гэрлэлтийг тэдний өргөдлийн дагуу шүүхээр цуцлах.

- 1. Хүүхэдтэй эхнэр, нөхөр шүүхэд гэрлэлтээ цуцлах тухай өргөдөл гаргахдаа хүүхдүүд нь тэдний хэнтэй нь амьдрах, тусдаа амьдрах эцэг юмуу эх нь хүүхдүүдийнхээ амьдралын нөхцлийн хангахад хэрхэн оролцох, хүүхдээ хүмүүжүүлэхэд оролцох эрхийг нь хангах ямар нөхцөл байх талаар тохирсон гэрээг бичгийн хэлбэрээр хавсаргах эрхтэй.*
- 2. Эхнэр, нөхрийн хооронд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тохирсон гэрээг нотариатаар баталгаажуулсан байна. Хэрэв гэрээг биелүүлээгүй тохиолдолд хүүхдийн тэтгэлгийг нотариатчийн гарын үсгийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гаргуулна.*
- 3. Шүүхээс гэрлэлт цуцлах тухай өргөдөл нь эхнэр, нөхрийн өөрсдийнх нь бодит хүсэлтэд нийцсэн, гэрлэлтийг цуцалсны дараа тэдний хувийн болон өмчийн эрх, мөн хүүхдийнх нь эрх зөрчигдөхгүй гэдгийг тогтоосноор гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана.*

4. Украинд өвлөх эрхийг зохицуулах хууль эрхийн гол актууд нь Иргэний хууль болон Нотариатын тухай хуулиуд байдаг. Иргэний хуулиар өвлөлийн тухай үндсэн ойлголтууд, өвлөлийн хэлбэрүүд, өвлөгчдийн тухай ойлголт, өвлүүлэх хугацаа, газар зэргийг нарийвчлан тодорхойлсон байдаг бол Нотариатын тухай хуулиар өвлөх эрхийг баталгаажуулах баримт бичгийг бүрдүүлэх процессийг тодорхойлсон байдаг.

Украины Иргэний хуулийн 1216 дугаар зүйлээр өвлөл гэж өмчтэй холбоотой эрх, үүрэг нас барсан этгээдээс өвлөгч болох бусад этгээдэд шилжихийг хэлнэ. Өвлөгч нь өвийг шилжүүлэх үед амьд байгаа хувь хүн болон хуулийн этгээд, улс, гадаад улс байж болно. Уг хуулиар хуулийн дагуу өвлөх болон гэрээслэлийн дагуу өвлөх гэсэн өвлөлийн хоёр хэлбэрийг тодорхойлсон. Иргэний хуулийн 85 дугаар бүлэг нь гэрээслэлийн дагуу, 86 дугаар бүлэг нь хуулийн дагуу өвлөх асуудлыг тусгасан байна.

Украины хууль тогтоомжоор хуулийн дагуу өвлөгчдийг тав эрэмбэлэн дараалал тогтооно. Иргэний хуулийн 1261 дүгээр зүйлээр дээрх дарааллын хамгийн эхэнд өвлүүлэгчийн хүүхдүүд, эхнэр юмуу нөхөр, эцэг, эх байна. Өвлүүлэгчийг амьд байхад олдоод, нас барсан хойно нь төрсөн хүүхэд ч энд орно. Хоёрдахь дараалалд өвлүүлэгчийн төрсөн ах, дүү, өвөө, эмээ нар; гуравдугаарт, авга, нагац ах, дүү нар; дөрөвдүгээрт, өвлүүлэгчтэй нэг гэр бүлд таваас доошгүй жил амьдарсан хүн; тавдугаарт, өвлүүлэгчийн зургаан үе хүртлэх төрөл садангийнхан орно.

Украины Иргэний хуулийн 1267 дугаар зүйлээр өвлөгчдөд өвөөс оногдох хувийг тогтооно:

- Өвлөгчдөд өвөөс оногдох хувь адил байна
- Өвлөгчид амаар тохиролцсоны дагуу хөдлөх хөрөнгийг тэнцүү бусаар хуваарилан авч болно
- Үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслээс оногдох хувийг өөрчлөх тохиолдолд өвлөгчдийн хэн нэг нь хүсвэл өвлөгчид хоорондоо бичгээр хэлцэл байгуулж, нотариатаар баталгаажуулна.

Хуулийн дагуу өвлөх тохиолдолд өргөмөл хүүхэд нь өвлүүлэгчийн төрсөн хүүхдүүдтэй адил өвлөх эрхтэй байна.

Украины Иргэний хуулийн 1233 дугаар зүйлээр гэрээслэл гэж хэн нэг хувь хүн өөрөө нас барах тохиолдолд эд хөрөнгийг нь хэрхэн хуваарилах, зарцуулах тухай хүсэлт юм. Уг хуулийн 1217 дугаар зүйлээр өвлөлийн хэлбэрийн нэгдүгээрт гэрээслэлийн дагуух өвлөлийг нэрлэх боловч өвлөгчдийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай үед өвлүүлэгчийн хүсэлт болох гэрээслэлийн заалтуудыг хязгаарлах хуулийн заалгалтууд бас байдаг.

Гэрээслэлд хэрхэн зааснаас үл хамааран өвөөс зайлшгүй ноогдох хувийн эрх гэж байна. Өвлүүлэгчийн насанд хүрээгүй хүүхэд, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр юмуу нөхөр, хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх нь гэрээслэлд хэрхэн зааснаас үл хамааран хэрэв хуулийн дагуу өвлөсөн бол авах ёстой хувийнхаа талыг нь заавал өвлөн авна. Үүнийг өвөөс зайлшгүй ноогдох хувь гэж нэрлэнэ. Өвлүүлэгч ба өвлөгчдийн хоорондын харилцааны гарцаагүй тооцвол зохих шалтгаан байгаа бол шүүхээс зайлшгүй ноогдох хувийг багасгаж болно.

Бүгд Найрамдах Литва улс

Литва улсын Иргэний шинэ хууль¹ 2000 онд батлагдсан ба нийт 6 боть номноос бүрдэнэ. Үүний 3 дахь ном буюу Гэр бүлийн эрх зүй² гэсэн ботид эцэг, эхийн хүүхдийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага, хүүхдийн эрх, түүний дотор өмчийн эрхийг нь хамгаалах асуудлыг хуульчилжээ.

¹ Гражданский кодекс Литовской Республики. <http://www3.lrs.lt>

² Семейное право

Тус хуульд эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдүүдээ тэжээн тэтгэж, хүмүүжүүлэх үүрэгтэй ба тэдний эрүүл мэнд, боловсрол, хувийн эрх, эрх чөлөө, дотоодын ба олон улсын эрх зүйгээр тодорхойлсон өмчийн, нийгмийн болон бусад эрхийг хангах үүрэгтэй болохыг хуульчилсан.

Литва улсын Гэр бүлийн эрх зүйн хуулийн II ангийн IV хэсгийн IV бүлэгт шүүхээс гэрлэлт цуцлалтын үед шийдвэрлэх асуудлын хүрээнд насанд хүрээгүй хүүхдийг тэжээн тэтгэх, орон байраар хангах, эцэг эх нь гэрлэлт цуцлах хүртэл тусдаа амьдарсан нөхцөлд насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх зэрэг бүлэг асуудлыг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- Шүүх гэрлэлт цуцлах үедээ гэр бүлийн насанд хүрээгүй хүүхдүүдийг тэжээн тэтгэх, тэдний амьдрах орон байрны асуудлыг шийдвэрлэнэ.
- Шүүх насанд хүрээгүй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс шүүхийн шийдвэр гарах хүртэл эх, эцгийн аль нэгнээр хүүхдийг түр тэжээн тэтгүүлэх урьдчилсан арга хэмжээ авахаар шийдвэрлэнэ.
- Орон байр нь эхнэр, нөхрийн аль нэгнийх нь өмчлөлд байдаг тохиолдолд насанд хүрээгүй хүүхдүүдтэй хамт амьдрахаар үлдэж байгаа талд нь шүүх узуфрукт³ тогтоохоор шийдвэрлэнэ. Узуфруктыг хүүхдийг насанд хүртэл нь тогтооно.
- Гэрлэлт цуцлах хүртэл гэрлэгсэд тусдаа амьдрах нөхцөлд насанд хүрээгүй хүүхдүүд хэнтэй нь хамт амьдрах болон тэднийг тэжээн тэтгэх, үүнд тусдаа амьдрах эцэг /эх/-ийн оролцоог шүүх шийдвэрлэнэ.

Тус хуулийн III ангийн VI хэсгийн I бүлгийн гэр бүлийн өмчийн эрх зүйн дэглэм гэсэн 3.85 дугаар зүйлд гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч бөгөөд хэрэв энэ эрхээ хэн нэгэнд шилжүүлэх, үл хөдлөх хөрөнгийг барьцаалах зэргээр захиран зарцуулахдаа заавал нөгөө хүнийхээ /эхнэр ба нөхрийн/ зөвшөөрлийг бичгээр авна. Харин тэд насанд хүрээгүй хүүхэдтэй тохиолдолд гэр бүлийн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн хэлэлцээ хийхэд заавал шүүхийн зөвшөөрөл шаардагдана гэж хуульчилжээ.

Мөн хуулийн III ангийн VIII хэсэг нь гэрлэгчдийн дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг зохицуулж байгаа ба тус хэсгийн 3.116 дугаар зүйлд гэрлэгсдийн хэн нэгний эсхүл зээл олгогчийн шаардлагаар гэрлэгчдийн дундын эд хөрөнгийг гэрээний дагуу ба шүүхийн шийдвэрээр хувааж болно гэж заасан.

Харин Хуваагдахгүй эд хөрөнгө гэсэн 3.120 дугаар зүйлд хуваагдах эд хөрөнгө насанд хүрээгүй хүүхдийн хэрэгцээг хангах зориулалттай эд зүйл хамаарахгүй ба эдгээр эд зүйл нь гэрлэлт цуцласан тохиолдолд насанд хүрээгүй хүүхдүүдийн хамт амьдрах хүнд нь ямар нэгэн нөхөн олговоргүйгээр шилжинэ гэж хуульчилжээ.

³ узуфрукт нь гэрээ буюу хуулийн дагуу тодорхой хугацаанд өөр этгээдийн зэмшилд байгаа эд хөрөнгийг түүнээс гарах үр шимтэй нь хамт тухайн эд юмсын мөн чанарыг алдагдуулахгүйгээр ашиглах эрх юм.

VIII хэсгийн Дундын эд хөрөнгийг ижил тэнцүү хуваах зарчмаас гажих гэсэн 3.123 дугаар зүйлд шүүх насанд хүрээгүй хүүхдийн эрх ашиг, гэрлэгсдийн хэн нэгний эрүүл мэнд, аж байдал, эсхүл бусад чухал шалтгаан нөхцлийг харгалзан дундын эд хөрөнгийг ижил тэнцүү хуваах зарчмаас гажиж, гэрлэгчдийн хэн нэгэнд дундын эд хөрөнгийн ихэнх хэсгийг хуваан өгөхөөр шийдвэрлэж болно хэмээн заасан.

Литва улсын Гэр бүлийн эрх зүйн хуулийн IV анги нь эцэг, эх, хүүхдүүдийн харилцан эрх, үүргийг зохицуулсан ба XI хэсгийн II бүлгийн Хүүхдийн эрх гэсэн 3.161 дүгээр зүйлийн 4-т хүүхдүүд эцэг эхийн эд хөрөнгийг өмчлөх эрхгүй харин эцэг, эх нь хүүхдийн эд хөрөнгийг өмчлөх эрхгүй гэж заасан. Мөн хүүхдийн эд хөрөнгийн эрхийг тус хууль болон иргэний хуулийн бусад ботид хуульчилсан болохыг заажээ.

IV ангийн XII хэсгийн I бүлэгт хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудлаарх эх, эцгийн эрх, үүргийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- Насанд хүрээгүй хүүхдийнхээ өмчлөлд байгаа эд хөрөнгийг эцэг, эх нь узуфруктын эрхээр захиран зарцуулна. Эцэг, эхийн энэхүү узуфруктын эрхийг барьцаалах, худалдах, ямар нэгэн байдлаар бусдад шижүүлэх болон түүнээс нэхэмжлэхийг хориглоно.
- Насанд хүрээгүй хүүхдийнхээ өмчлөлд байгаа эд хөрөнгийг эцэг, эх нь хэлэлцэн тохирсоны үндсэн дээр захиран зарцуулах ба хэрэв энэ асуудлаар маргаан гарвал тэдний хэн нь ч эд хөрөнгийг захиран зарцуулах дэг журам тогтоолгох хүсэлтийг шүүхэд гаргаж болно.
- Хэрэв эцэг, эх, эсхүл тэдний хэн нэг нь насанд хүрээгүй хүүхдийнхээ эд хөрөнгийг зохисгүй байдлаар захиран зарцуулж, хүүхдийн эд хөрөнгийн эрх ашигт хохирол учруулбал хүүхдийн эрхийг хамгаалах төрийн байгууллага болон прокурорын байгууллага насанд хүрээгүй хүүхдийн эд хөрөнгийг захиран зарцуулж байгаа эцэг, эхийн эрхийг хасах талаар шүүхэд хандах эрхтэй. Энэ нь хэрэв үндэслэлтэй бол шүүхээс эцэг, эхийн хүүхдийн эд хөрөнгийн узуфруктын эрхийг цуцалж, энэ хөрөнгийг захирах өөр хүнийг томилох ба дээрх үндэслэл үгүй болсон нөхцөлд эцэг, эхийн узуфруктын эрхийг дахин сэргээж болно.
- Эцэг, эх насанд хүрээгүй хүүхдийнхээ эд хөрөнгийг зөвхөн хүүхдийн эрх ашгийн үүднээс л захиран зарцуулах үүрэгтэй. Энэхүү эд хөрөнгөнөөс олсон ашиг, орлогыг эцэг, эх хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан гэр бүлийн хэрэгцээнд ашиглаж болно.
- Хүүхдийн өөрийн хөдөлмөрлөж олсон орлогоороо бий болгосон, түүний боловсрол, сонирхол, чөлөөт цагт зориулагдсан өмчид болон хүүхдэд бэлэглэсэн, узуфрукт тогтоохгүй гэсэн нөхцөлтэйгээр өвлүүлсэн өмчийг нь эцэг, эх нь узуфруктын эрхээр захиран зарцуулах эрхгүй.
- Хүүхдийг 16 насанд хүрэхэд нь хуулийн дагуу бие даах чадвартай гэж үзсэн, хүүхэд хуулийн дагуу гэрлэсэн, насанд хүрсэн, шүүхээс эцэг, эхийн хүүхдийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг цуцласан, шүүхээс хүүхдийг эцэг, эхээс нь тусгаарласан эсхүл тэдний эрх мэдлийг

хязгаарласан тохиолдолд эцэг, эхийн насанд хүрээгүй хүүхдийнхээ эд хөрөнгийг захиран зарцуулах, узуфруктын эрх дуусгавар болно.

- Эцэг, эхийн узуфруктын эрх дуусгавар болсны дараа тэд хүүхдийн эд хөрөнгийг ашигласаар байгаа тохиолдолд эцэг, эх /эсхүл хүүхэдтэй амьдарч байгаа эцэг, эхийн хэн нэг/ хүүхдэд эд хөрөнгийг нь төдийгүй эд хөрөнгөнөөс олсон ашиг, орлогыг хүүхэд ба түүний төлөөлөгчийн шаардсан цаг, хугацаанаас эхлэн буцаан өгөх ёстой.

Литва улсад өв залгамжлах асуудлыг Иргэний хуулийн тавдугаар ботиор зохицуулсан байна. Юуны өмнө өв залгамжлагчдыг уг хуулийн 5.11 зүйлийн нэгдүгээр хэсгээр дараах байдлаар эрэмбэлэн дараалал тогтооно:

- 1) Өв үлдээгчийн хүүхдүүд, үүнд үрчилж авсан болон нас барсны нь дараа төрсөн хүүхэд мөн орно
- 2) Өв үлдээгчийн эцэг, эх, ач, зээ, үүнд өргөж авсан эцэг, эх орно
- 3) Өв үлдээгчийн өвөг эцэг, эх: эцгийн болон эхийн талынх адилхан орно. Мөн гуч хүүхдүүд
- 4) Өв үлдээгчийн төрсөн ах, дүү нар, эцгийн болон эхийн талын элэнц эцэг, эх
- 5) Өв үлдээгчийн төрсөн ах, дүү нарынх нь хүүхдүүд, эцэг, эхийнх нь төрсөн ах, дүү нар
- 6) Өв үлдээгчийн эцэг, эхийн төрсөн ах, дүү нарын хүүхдүүд.

5.11 зүйлийн хоёрдахь хэсэг ёсоор дээрх дарааллын хоёрдугаарт байгаа этгээд хэрэв өв үлдээгч нь дарааллын нэгдүгээрт орох хүүхэдгүй, эсвэл хүүхдүүд нь өвийг хүлээж аваагүй юмуу авахаас татгалзсан, эсвэл өвлөх эрхгүй болсон тохиолдолд өвийг авна гэх мэтээр дарааллын цааших хэсэгт орсон хүмүүс өвлөх эрхтэй болно. Иймд өв үлдээгч хүүхэдтэй байсан бол бүх өв юуны өмнө хүүхдэд нь очно. Энэ тохиолдолд өвлүүлэгчийн ач, зээ нь өв авахгүй.

Гэхдээ Иргэний хуулийн дагуу ач, зээ нь өвлүүлэгчийн хүүхдүүдтэй адилаар өвлөх тохиолдол бий. Уг хуулийн 5.12 дугаар заалтаар өвлүүлэгчийн ач, зээ, гучууд эцэг, эх нь нас барсан, өөрөөр хэлбэл өвлүүлэгчийн хүүхэд нь нас барсан тохиолдолд өвлүүлэгчийн бусад хүүхэдтэй адилаар өв залгамжлана.

Иргэний хуулиар өв үлдээгчийн эхнэр юмуу нөхөр мөн өв залгамжлан авна. Хуулийн 5.13 дугаар заалтаар үлдсэн эхнэр юмуу нөхөр нь нэгдүгээр дараалалд орж буй хүүхдүүдтэй нэг ээлжинд өв авах бөгөөд хэрэв энэ дарааллын өв залгамжлагчид гурваас илүүгүй бол бүх өвийн дөрөвний нэгийг, хэрэв энэ дарааллын өв залгамжлагчид нь гурваас илүү бол бүгд тэнцүү өв авна. Хэрэв эхнэр юмуу нөхөр нь дарааллын хоёрдугаарт орох өв залгамжлагчид болох ач, зээ нартай өв хуваан авах бол өвийн тал нь эхнэр юмуу нөхөрт оногдоно. Хэрэв дарааллын нэг болон хоёрдугаарт орох өв залгамжлагчид байхгүй бол эхнэр юмуу нөхөр нь бүх өвийг залгамжлан авна.

Хэрэв өв залгамжлах дээрх дарааллаас өөрөөр өвөө үлдээх хүсэлтэй бол гэрээслэлээр өвөө залгамжлуулж болно.

Канад улс

Канад улсад Гэр бүлийн дундын хөрөнгөөс хүүхдэд оногдох хувь хэмжээ болон **хүүхэд эд хөрөнгө өвлөх, өмчлөх** тухай харилцааг Гэрлэлтийн тухай хууль

/Marriage act/, Гэр бүл салалтын тухай хууль /Divorce act/, Гэр бүлийн тухай хууль /Family act/, Иргэний хууль /Civil code/, Хүүхдийн тухай хууль /Children's law act/ зэрэг хуулиудаар зохицуулдаг байна.

Гэр бүл цуцлалт: Канад улсад хэрвээ хэн нэгэн гэрлэлтээ цуцлуулахаар шийдвэл хүүхдээ өсгөх, асран хүмүүжүүлэх төлөвлөгөө гаргах, өөрийн санхүүгийн байдал, бүх эд хөрөнгийн жагсаалт, өр зээл, орлого ба зарлагын мэдээлэлүүдийг тодорхой болгож бэлтгэсэн байх ёстой. Хүүхэд асрах төлөвлөгөөг хоёул хамтран гаргах эсвэл шүүхээр шийдүүлж ч болно. Үүнд маш олон зүйл хамаарна. Тухайлбал,

- Хүүхдүүдийг өсгөн хүмүүжүүлэхэд шаардагдах зардал- эдгээр өртөгийг гэрлэлтээ цуцлуулсан хоёр хуваан гаргах болно.
- Хүүхдийн тэтгэмж - нэг нь нөгөөдөө хүүхдийн тэтгэмж төлөх шаардлага гарна.
- Гэр бүлийн дэмжлэг - нэг нь нөгөөдөө тодорхой бус эсвэл тодорхой хугацаагаар гэр бүлийн дэмжлэг тэтгэмж төлөх шаардлага гарах магадлалтай.
- Өмч хөрөнгөө хуваах нь - дундын өмч хөрөнгийг гэрлэлтээ цуцлуулсан хоёр хуваан авна.
- Эцэг эх салсаны дараа ч хоёулаа хүүхдүүдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Тэд чухам хэдий хэмжээгээр хувь оруулах вэ гэдэг нь Холбооны хүүхдийн тэтгэлгийн гарын авлаганд тодорхойлсон байдаг ба эцэг эхийн санхүүгийн чадвар, хүүхдүүдийн хэрэгцээ зэргээс хамааран тогтоогдоно. Аль ч шатны шүүхэд хүүхдийн тэтгэмж дэмжлэгийн асуудлыг хангалттай сайн шийдвэрлээгүй л бол гэр бүл салалтыг зөвшөөрөн шийдвэрлэдэггүй.

Иргэний хуулийн 3-р бүлгийн 381-р зүйлд заасны дагуу гэр бүл салсан нь хүүхдийн хуулиар, гэрлэлтийн гэрээгээр заасан эрхийг ямар ч тохиолдолд зөрчиж үл болно. Энэ нь гэр бүл салсан ч гэсэн эцэг эхийн хүүхдийн өмнө хүлээсэн үүрэг хадгалагдана гэсэн үг юм. Мөн хуулийн 388-р зүйлд зааснаар *Шүүх нь гэрлэгчдийн эд хөрөнгийг хуваахдаа дараах зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд: Хүүхдийн боловсролд шаардлагатай зардал болон хэрэв шаардлагатай бол нөхөн олговрыг хувиарлана* гэж заажээ.

Ихэнх тохиолдолд нэг нь хүүхдүүдээ асран хүмүүжүүлж, нөгөө нь тэдэнтэйгээ харилцан уулзаж дэмжин тэтгэх бололцоогоор хангагддаг. Уулзах гэдэгт нь хамт хонохыг хүртэл оролцуулна. Бас хүүхдүүдийнхээ эрүүл мэндийн байдал, боловсрол, нөхцөл байдлын тухай бүрэн мэдээлэл авч байх ёстой. Асран хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн нь ямар сургуульд суралцах, ямар шашны зан үйлд оролцох ба өдөр тутмын амьдралын хэв маяг зэргийг нь шийдэх эрхтэй. Ингэхдээ хүүхдийн болон нөгөөгийнхөө санаа бодлыг ямагт бодолцон үзэхийг чухалчилдаг байна. *Шүүхээс хүүхэдтэй холбоотой аливаа өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ хүүхдийн санааг илүү харгалзан шийдвэрлэнэ.*⁴

Гэрлэлтийг хүчингүй гэж тооцох эсхүл эд хөрөнгийг салгах үед шүүх нь гэрлэгсдийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх эрхийг өөрийн мэдлийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд аль амьдрах чадвар багатайд нь эсвэл хүүхдийг асран халамжлах эцэг буюу эхэд нь өгөх тохиолдол их байдаг байна.

Гэр бүлийн дундын өмч хөрөнгө хуваах: Канадын хуулиар⁵ **Гэр бүл цуцлалтын үед** гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваахад **хүүхдэд ногдох хувь**

⁴ Гэр бүл салалтын тухай хууль 15.3 (1) Divorce Act R.S.C., 1985, c. 3 (2nd Supp.)

⁵ http://www.lawsociety.ab.ca/public/legal_education/divorce_separation.aspx

хэмжээ гэж байдаггүй. Харин зөвхөн хуучин эхнэр нөхөр хоёр гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваан авах эрхтэй байдаг байна. Тэд хамтын хүч хөдөлмөрөөр хураасан өмч хөрөнгийг адил тэгш хуваан авна гэсэн зарчим голчлон үйлчилнэ. Ихэнх тохиолдолд, гэр ахуйгаа авч явдаг ба орлого олдог хоёрыг адил тэгшид үздэг байна.

Хүүхдийн эд хөрөнгө: Хүүхдийн тухай хуулинд хүүхдийн эрх, үүргийг хуульчилсан бөгөөд хуульд зааснаар хүүхэд төрснөөс хойш өөрт зориулагдсан эд хөрөнгөө өмчлөх эрхтэй бөгөөд насанд хүрээгүй тохиолдолд хүүхдийн эд хөрөнгийн эрхлэн хамгаалагч нь эцэг эх нь байдаг байна. Хүүхдийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 57-66 дугаар зүйлд хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудлаарх эх, эцгийн эрх, үүргийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- Хоорондоо тохиролцсон мөн шүүхийн шийдвэрийн дагуу эцэг эх хоёр нь адил эрхтэйгээр хүүхдийн өмчлөлийн **эрхлэн хамгаалагчид** байх бөгөөд тэдгээр нь хамтран өмчлөлийн зүйлийг удирдах болон тэр асуудлаар хариуцлага хүлээнэ.
- Хүүхдийн эцэг эх эсхүл асран хамгаалагчаас хүүхэдтэй холбоотой дараах үйлдлийг хийхэд шүүхээс зөвшөөрөл авна. Тухайлбал, Ашиг сонирхол бүхий газрын хувьд эрхийг хасах, Хүүхдийн өмчийг зарах, Бүх төрлийн мөнгөн төлбөр тооцоо \хүүхдийн үл хөдлөх хөрөнгө түүний эрхээс орж ирж буй орлого\ зэрэг болно.
- Хуулиар хориглоогүй бол асран хамгаалагч нь хуульд заасны дагуу тэдгээрийн эрхийг хамгаалах шүүхэд төлөөлөх, мөн бусад үүргийг хэрэгжүүлэх эрхтэй.
- Эрхлэн хамгаалагч нь хуульд заасан үндэслэлээр, шүүх зөвшөөрсний үндсэн дээр эрхлэн хамгаалагчийн үүргээс чөлөөлөгдөж болдог.

Шүүх нь хүүхдийн **өмчлөлд эрхлэн хамгаалалт тогтоохдоо** тухайн этгээдийн өмчлөлийн зүйлийг удирдах чадвар, тухайн өмчлөлийн зүйлийн удирдлагийн талаар гаргаж өгсөн төлөвлөгөө, хүүхдийн санал бодол зэргийг харгалзан үздэг байна.

Хүүхэд өөрийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн харилцааны дагуу өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Харин тухайн хүүхэд 19 нас хүрэх үед эд хөрөнгийн эрхлэн хамгаалагч нь хүүхдийн өмчлөлийг хууль ёсны өмчлөгч болох хүүхдэд хүлээлгэн өгөхөөр хуульд заасан байна.

Энэ мэтчилэн Канадын улсын хуулиар хүүхэд өөрт зориулагдсан эд хөрөнгийг өмчлөх эрхтэй бөгөөд өөрийн эцэг эх болон ойр дотныхоо хүмүүсээс хуулиар болон гэрээслэлээр эд хөрөнгө өвлөх авах боломжтой байдаг байна.

Швед улс

Швед улсад гэр бүлийн дундын хөрөнгийг өвлөх, өмчлүүлэх харилцааг “Гэр бүлийн тухай хууль/1987”, “Гэр бүл салалтын тухай хууль”, “Гэрлэлтийн тухай хууль”, “Иргэний хууль”, “Хүүхэд ба эцэг эхийн тухай хууль”-аар зохицуулдаг байна.

Шведийн Гэр бүл салалтын тухай хууль⁶ нь гэрлэлтийг цуцлах, хүүхдийн тэтгэмж ба эд хөрөнгийг хуваах зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг. Шведэд гэр бүл цуцлах үед дундын эд хөрөнгийг хувиарлахдаа хүүхдэд ямар нэгэн байдлаар хувь

⁶Гэр бүл салалтын тухай хууль. http://en.wikipedia.org/wiki/Divorce_law_in_Sweden

хэмжээ оногдуулах тухай заалт байхгүй бөгөөд харин гэрлэлтээ цуцлуулж буй эхнэр нөхөр нь дундын эд хөрөнгөө шүүхийн дагуу хуваан авах эрхтэй байдаг байна.

Гэр бүл цуцлуулах үед дундаасаа хүүхэдтэй бол хүүхдийн амьдрах таатай орчин, боловсролын асуудал, сэтгэл санааны болон аюулгүй байдлын талаарх бүхий л асуудлыг хүүхдэд таатай байдлаар бүрэн шийдвэрлэхийг шаардахаас гадна хүүхдийн амьжиргааны зардалд зориулсан тэтгэмжийг эцэг эхийн хэн нэгнээс гаргуулдаг.

Харин эцэг эх нь нас барсан тохиолдолд хүүхэд эд хөрөнгийг гэрээслэлээр болон хуулиар өв залгамжлах эрхтэй байдаг. Тухайлбал, **Гэр бүлийн тухай хуулинд**⁷ “Хэрвээ нас эцэслэсэн хүн гэрлэсэн бөгөөд гэр бүлийн дундын өмчлөлийн хөрөнгө бүхий бол нас барсан хүний эд хөрөнгийг хуваан хуваарилахын өмнө эхлээд заавал гэр бүлийн дундын хөрөнгийг хуваах ёстой. Энэ нь нас барсан хүн хамтран амьдрагч байсан тохиолдолд мөн адил үйлчлэх ба, амьд үлдсэн хамтран амьдрагч нь эд хөрөнгө хуваах хүсэлтийг гаргана. Хэрвээ талийгаач гэрлээгүй хүн байсан бол шууд өв залгамжлагчид нь (хүүхдүүд, ач хүүхдүүд, гэх мэт) түүний хөрөнгийг өвлөн авах үндсэн эрхтэй. Эдгээр нь нэгдүгээр өвлөн авах ангид хамаардаг. Хамгийн эхний ээлжинд хүүхдүүд нь өвлөн авна. Хэрвээ талийгаачийн аль нэг хүүхэд түүнээс өөрөөс нь өмнө нас барсан бол (эсвэл өв залгамжилахаас татгалзвал) түүний хүүхдүүдэд нь эрхийг нь шилжүүлнэ.

Шведэд хүүхэд өөрийн эцгээс хөрөнгө өвлөн авах эрхтэй.⁸

1970 оны 1-р сарын 1-ний хойш эцэг эх нь албан ёсоор гэрлээгүй байсан ч хүүхдүүд эцэг, эхийн аль алианаас эд хөрөнгө өвлөн авах тэгш эрхтэй болсон. Урьд өмнө нь зөвхөн хэрвээ эцэг нь эхтэй нь гэрлэсэн бол хүүхэд эцгээсээ эд хөрөнгө өвлөх эрхтэй байв. Зарим тохиолдолд хэрвээ эцэг, эх нь хоорондоо гэрлэхээр сүй тавьсан байсан эсвэл хэрвээ эцэг эд хөрөнгөө өвлүүлэх гэрээслэл үлдээсэн бол гэх зэрэг нөхцөлүүдийг харгалзан үздэг байсан.

1970 оноос өмнө төрсөн бөгөөд эцэг эх нь хоорондоо гэрлээгүй хүүхдэд хөрөнгө өвлөх тухай асуудал үүсэхэд эцэг нь нас барахаас өмнө хүүхдийн тухай тэмдэглэл хотын иргэний бүртгэлийн газар дахь хувийн бичиг баримтад нь орсон, эсвэл хүн амын тоололгын бүртгэлд хүүхэд эцэгтэйгээ хамт эс бөгөөс эд хөрөнгө өвлөн авах эрх үүсэх хэн нэгэнтэй хамт бичигдсэн байх аваас түүнд хөрөнгө өвлөх эрх үүснэ. Хэрвээ тийм бүртгэл тэмдэглэлгүй бол эцгийн нас барсанаас хойш 3 сарын дотор тухайн хүүхэд эд хөрөнгийн эзнээс буюу эзэмшигчээс хувь хүртэх ёстой бусад хүмүүст мэдэгдсэн байх тохиолдолд л өвлөх эрх үүснэ.

Гэрээслэлээр хүүхэд эд хөрөнгө өвлөн авах эрхтэй.⁹

Хэн нэгэн хүн өөрийн эд хөрөнгийн өв залгамжлагчаа гэрээслэлээрээ шийдвэрлэх боломжтой. Эхнэр нөхөр хоёр хэн нэгийгээ түрүүлж нас барсан даруйд л хүүхдүүдээ эд хөрөнгөө өвлүүлэхийг хүсч байж болно. Энэ тохиолдолд тэд заавал гэрээслэл үйлдэх ёстой. Ямар ч гэрээслэл хүүхдүүдийн хууль ёсны хувь хэмжээг өөрчлөхгүй. Гэрээслэлээр эд хөрөнгийг бүхэлд нь өөр хүнд өвлүүлэхээр

⁷ Швейдын Хууль Зүйн Яамнаас 2009 онд эрхлэн гаргасан "Гэр бүлийн хууль" хэмээх брошюраас: Гэр бүлийн хууль, 2.7, 3.2-р хэсэг <http://www.government.se/content/1/c6/13/83/44/12624b3b.pdf>

⁸ Өв залгамжлалын тогтоол. <http://www.government.se/content/1/c6/13/83/44/12624b3b.pdf> -

⁹ Өв залгамжлалын тогтоол. <http://www.government.se/content/1/c6/13/83/44/12624b3b.pdf> -

шийдсэн байвч хүүхдүүд нь тус тусын хувь хэмжээг шаардах эрхтэй. Тэр хувь хэмжээнээс гагцхүү өөрсдөө л татгалзах эрхтэй.

Бүгд Найрамдах Хятад Ард улс

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Гэрлэлтийн тухай хууль

Энэхүү хууль нь 1980 оны 9 сарын 10-ны тавдугаар Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын 3 дахь удаагийн хурлаар батлагдсан бөгөөд 1981 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь нийт 6 бүлэг 51 зүйлтэй, гэрлэлт, гэр бүлийн харилцаа, гэрлэлт цуцлалт, хуулийн хариуцлага, бусад зүйл заалт зэрэг гэр бүлийн харилцааны үндсийг хуульчилсан. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Гуравдугаар бүлгийн 24-р зүйлд зааснаар:

Эхнэр нөхөр харилцан хоорондоо эд хөрөнгөө өв залгамжлах эрхтэй.

Эцэг эх болон хүүхэд харилцан хоорондоо эд хөрөнгөө өв залгамжлах эрхтэй.

Дөрөвдүгээр бүлгийн 37-р зүйлд зааснаар:

Гэрлэлтээ цуцлуулсны дараа, эцэг эхийн нэг нь хүүхдээ асран хамгаалах бөгөөд нөгөө нь хүүхдийг тэжээн тэтгэхэд шаардагдах тэтгэлэг болон сурч боловсрох тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь гаргана. Гаргуулах тэтгэлгийн хэмжээ болон хугацааг тогтоохдоо талууд харилцан тохиролцож гэрээ байгуулах ба харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол Ардын шүүх тогтооно.

Хүүхдийн тэтгэлэг болон сурч боловсрох тэтгэлгийг талууд харилцан тохиролцож гэрээ байгуулсан эсвэл шүүх тогтоосон хэдий ч, хүүхэд шаардлагатай тохиолдолд тогтоосон тэтгэлгээс хэтэрсэн хэмжээний мөнгийг эцэг эхийн аль нэг талаас гаргуулахаар нэхэмжлэл гаргаж болно.

Түүнчлэн 39-р зүйлд зааснаар:

Гэрлэлтээ цуцлуулах үед гэрлэгчид хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваахдаа талууд харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэх ба харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол эд хөрөнгийн бодит байдал, хүүхэд асран хамгаалах мөн эмэгтэйн талын эрх, ашиг сонирхолд үндэслэн Ардын шүүх шийдвэрлэнэ.

40-р зүйлд зааснаар:

Гэрлэгчдийн хооронд гэрлэлтийн харилцаа албан ёсоор үүссэн хугацаанд олсон эд хөрөнгө нь өөр өөрт нь харьяалагдах бөгөөд гэрлэгчдийн нэг тал нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, өндөр настай хүнээ асарч тэтгэх, нөгөө талынхаа ажилд тусалсан зэрэг илүү үүрэг гүйцэтгэсэн гэх шалтгаанаар, гэрлэлтээ цуцлуулах үед

нөгөө талаас нөхөн төлбөр гаргуулах хүсэлт гаргаж болох ба нөгөө тал нь энэхүү нөхөн төлбөрийг төлнө.

Мөн тус хуулийн 42-р зүйлд зааснаар:

Гэрлэлтээ цуцлуулах үед, хэрэв гэрлэгчдийн нэг тал нь хүнд хэцүү амьдралтай бол нөгөө тал нь орон сууц зэрэг өөрийн хувийн эд хөрөнгөөр тусалж тэтгэнэ. Энэ талаар талууд харилцан гэрээ байгуулах ба харилцан гэрээ байгуулаагүй бол Ардын шүүх шийдвэрлэнэ.

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Иргэний хууль

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Иргэний хууль нь 1986 оны 4 сарын 12-ны зургадугаар Бүх Ардын Төлөөлөгчдийн их хурлын 4 дэх удаагийн хурлаар батлагдсан бөгөөд 1987 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь нийт 9 бүлэг 156 зүйлтэй, иргэн, хуулийн этгээд, иргэний хуулийн үйлдэл, төлөөлөл, иргэний эрх, иргэний хариуцлага, шүүх үйл явцын хугацаа, бусад зүйл зэрэг иргэний харилцааны үндсэн зарчмыг хуульчилсан. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Хоёрдугаар бүлгийн 21-р зүйлд зааснаар:

Алга болсон хүний эд хөрөнгийг тухайн хүний эхнэр нөхөр, эцэг эх, насанд хүрсэн хүүхэд эсвэл харилцаа сайтай бусад төрөл садан, найз нөхдөөр захиран хадгалуулна. Хэрэв захиран хадгалахтай холбоотой маргаан үүсвэл, дээр дурдаагүй хүн эсвэл дээр дурдсан хүмүүс захирах чадваргүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Түүнчлэн тавдугаар бүлгийн 76-р зүйлд зааснаар:

Хуулийн дагуу иргэн эд хөрөнгө өв залгамжлах эрхтэй.

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Өв залгамжлах тухай хууль

1985 оны 4 сарын 10-ны тавдугаар Бүх Ардын Төлөөлөгчдийн их хурлын 3 дахь удаагийн хурлаар батлагдсан бөгөөд 1985 оны 10 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь нийт 5 бүлэг 37 зүйлтэй, хууль ёсны өв залгамжлагч, өв хөрөнгө өвлүүлэх, өв хөрөнгийн зохицуулалт, бусад зүйл зэрэг иргэдийн хувийн өв хөрөнгийг өвлүүлэх харилцааны үндсийг хуульчилсан. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Хоёрдугаар бүлгийн 10-р зүйлд зааснаар:

Өв хөрөнгийг дараах жагсаалтын дарааллаар өв залгамжлуулна.

Нэгдүгээрт: эхнэр нөхөр, хүүхэд, эцэг эх

Хоёрдугаарт: Ах эгч дүү, өвөө эмээ

Өв залгамжлахдаа, нэгдүгээр дарааллын өв залгамжлагчаар өв залгамжлуулах ба хоёрдугаар дарааллын өв залгамжлагч өв залгамжлахгүй. Хэрэв нэгдүгээр дарааллын өв залгамжлагч байхгүй тохиолдолд хоёрдугаар өв залгамжлагчаар өв залгамжлуулна.

Түүнчлэн 28-р зүйлд зааснаар:

Өв хөрөнгө хуваах үед урагт өв залгамжлах хувийг хадгалж үлдээх ёстой. Хэрэв ураг төрөхдөө эндвэл, хадгалж үлдээсэн өв хөрөнгийн хувийг хуулийн дагуу өв залгамжлагчид өгнө.

Хонг Конг

Гэрлэлтийн үйл ажиллагаа ба хөрөнгийн тухай журам, 1972 оны 7 сарын 1
ICAP 192 Matrimonial Proceedings and Property Ordinance (1 July 1972)/

Тус хууль нь 1972 онд батлагдсан ба нийт 3 бүлэг 33 зүйлтэй, хууль ёсны гэрлэлтийн үйл ажиллагаа эхлэх, гэрлэлтийн шүүх үйл явц, гэрлэлтийн үйл явцын бусад нэмэлт тусламж дэмжлэг, бусад зүйл зэрэг гэр бүлийн харилцааны үндсийг хуульчилжээ. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Нэгдүгээр бүлгийн 5-р зүйлд зааснаар:

Гэрлэлт цуцлах тохиолдолд хүүхдийн санхүүгийн нөхцөл

- 1) Энэ хуулийн 10-р зүйлд харшлахгүй бол, гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, эсвэл хуулийн дагуу тусдаа амьдрах талаар хуулийн процесс явагдах үед, шүүх доор заасан хугацаанд энэ заалтын 2-р хэсэгт заасан нэг эсвэл хэд хэдэн шийдвэрийг гаргана:
 - а. Гэрлэлт цуцлах, гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцох, хуулийн дагуу тусдаа амьдрах шийдвэр гарах тухайн үед эсхүл шийдвэр гарахаас өмнө буюу дараа
- 2) Дээрх 1-р хэсэгт заасан шүүхийн шийдвэр нь :
 - а. Гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүлийн гишүүн, хүүхдэд эсвэл тухайн хүүхдийнхээ ашиг сонирхолын үүднээс шүүхийн шийдвэрт заасан хүнд, шүүхийн шийдвэрт заасан хугацаа, хэлбэрийн дагуу тэтгэлэг олгоно.
 - б. Гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүлийн гишүүн, хүүхдэд эсвэл тухайн хүүхдийнхээ ашиг сонирхлын үүднээс шүүхийн шийдвэрт заасан хүнд, шүүхийн шийдвэрт заасан хугацаа, болон хэлбэрийн дагуу тэтгэлэг олгох шүүхийн шийдвэрийг биелүүлэх баталгааг шүүхэд гарган өгнө.

- с. Гэрлэгчдийн хэн нэг нь хүүхдэд эсвэл тухайн хүүхдийнхээ ашиг сонирхолын үүднээс шүүхийн шийдвэрт заасан хүнд, шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг бүхэлд нь нэг удаа төлнө.

Мөн түүнчлэн 6-р зүйлд зааснаар:

Гэрлэлт цуцлах тохиолдолд эд хөрөнгийн шилжүүлэлт, өмч эзэмших эрхийг шилжүүлэх, өөрчлөх тухай шүүхийн шийдвэр

- 1) Энэ хуулийн 10 ба 25-1-т харшлахгүй бол, гэрлэлт цуцлах, гэр бүл хүчин төгөлдөр бус гэж тооцох, эсвэл хуулийн дагуу тусдаа амьдрах тухай шүүхийн шийдвэр гарах үед эсвэл дараа нь, шүүх доор заасан нэг эсвэл хэд хэдэн шийдвэрийг гаргана:
 - а. Гэрлэгчдийн нэг тал нь шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг нөгөө талдаа эсвэл гэр бүлийн гишүүн хүүхдэд, эсхүл тухайн хүүхдийн ашиг сонирхолын үүднээс шүүхийн шийдвэрт заасан хүнд шилжүүлнэ. Гэхдээ тухайн эд хөрөнгөний эзэмших эрх болон буцаан авах эрх нь анхны эзэмшигчид байна.
 - б. Гэрлэгчдийн нэг тал ба хүүхдийн, эсхүл энэ хоёрын аль нэгний ашиг сонирхолын үүднээс шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх тухай баталгааг гэрлэгчдийн нөгөө тал нь шүүхэд гарган өгнө.

Финланд улс

Гэрлэлтийн тухай хууль (234/1929) /Marriage Act (234/1929)/

Тус хууль нь 1929 онд батлагдсан ба нийт 5 хэсэг 20 бүлэг 142 зүйлтэй, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, гэрлэгчдийн хууль ёсны харилцаа, гэрлэгчдийн хамтын эд хөрөнгийн хуваалт, хувийн олон улсын хууль дүрэм зэрэг, гэр бүлийн харилцааны үндсийг хуульчилжээ. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Нэгдүгээр хэсгийн зургаадугаар бүлгийн 24-р зүйлд зааснаар:

1. Гэрлэгчдийн хамтран гаргасан өргөдлийн дагуу эсхүл аль нэг талын гаргасан өргөдлийн дагуу шүүх дараах шийдвэрийг гаргана:
 - 1- Гэрлэгчдийн талуудаас илүү орон сууцны хэрэгцээтэй байгаа тал нь хамтран өмчлөх дундын орон сууцандаа үргэлжлүүлэн амьдрах эрхтэй.
 - 2- Гэрлэгчдийн нөгөө тал нь хамтран өмчлөх дундын орон сууцаа чөлөөлнө.
 - 3- Гэрлэгчдийн хамтын хэрэглээний эсвэл нэг талын, хүүхдийн хувийн хэрэглээний хэрэгсэл, гэрийн эд хөрөнгө болон нэг талын эзэмшлийн хөдлөх хөрөнгийг тухайн талдаа хэрэглэх эрхийг олгоно.

Мөн түүнчлэн хоёрдугаар хэсгийн хоёрдугаар бүлгийн 39-р зүйлд зааснаар:

- 1 Гэрлэгчдийн аль нэг талын зөвшөөрөлгүйгээр, нөгөө тал нь дараах эд хөрөнгийг шилжүүлэх эсвэл өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглоно:
 - Гэрлэгчдийн талуудын хамтран хэрэглэж буй хамтын эзэмшлийн дундын хөдлөх хөрөнгө
 - Гэрлэгчдийн хэн нэгний хэрэглэж буй хэрэгцээтэй хэрэгсэл
 - Гэрлэгчдийн хэн нэгний эсвэл хүүхдийн хувийн хэрэглээний хөдлөх хөрөнгө

Дөрөвдүгээр бүлгийн 46-р зүйлд зааснаар:

2- Гэрлэгчид харилцан байгуулсан гэрээний дагуу эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гэрлэгчдийн нэг талаас нөгөө талдаа төлөх асран хамгаалах тэтгэлгийн хэмжээ болон хэлбэрийг тогтооно.

3- Эцэг эхээсээ эдлэх хүүхдийн асран хамгаалах эрхийг “Хүүхэд асран хамгаалах тухай хууль”-аар зохицуулна.

Өв залгамжлах тухай хууль (40/1965) /Code of Inheritance (40/1965)/

Тус хууль нь 1965 онд батлагдсан ба нийт 26 бүлэг 212 зүйлтэй, өв залгамжлах эрх, төрөл садангийн өв залгамжлах эрх, гэрлэгчдийн хоорондын өв залгамжлах эрх, эд хөрөнгийн захиран зарцуулах, эзэнгүй эд хөрөнгийг хураах, гэрээслэл, гэрээслэл хүчингүй болох, өв хөрөнгийн үнэлгээ, өмчийг өв залгамжлагчдад хуваах зэрэг иргэдийн өв залгамжлах харилцааны үндсийг хуульчилжээ. Тус хуульд заасан хүүхдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтуудаас дурдвал:

Хоёрдугаар бүлгийн 1-р зүйлд зааснаар:

- 1- Төрсөн үр удам өв залгамжлах тэргүүн ээлжийн эрхтэй.
- 2- Хүүхэд бүр өв залгамжлах тэгш эрхтэй. Хэрэв хүүхэд нас барвал, түүний үр удам нь түүнийг орлох ба үр удам бүр тэгш эрхтэй.

Мөн түүнчлэн зургадугаар бүлгийн 2-р зүйлд зааснаар:

1- Хүүхдийн өсгөн хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, боловсрол олгоход эцэг болон эхээс гаргасан зардлыг тус хүүхдийн өв залгамжилсан өв хөрөнгөөс хасаж суутгахгүй.

2- Гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үзээд, хүүхдэд боловсрол олгоход зарцуулсан нэмэлт зардлыг тухайн нөхцөл байдалд тохирсон шалтгаантай гэж үзвэл суутгаж болно.

Наймдугаар бүлгийн 1-р зүйлд зааснаар:

Хэрэв талийгаачийн хүүхдэд өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгоход мөнгө хэрэгцээтэй бол мөн түүнчлэн тухайн хүүхдийг өв залгамжлагчид багтаан оруулсан бол, тухайн нөхцөл байдалд тохирсон шалтгаантай гэж үзвэл, тухайн

хүүхдийг хамгийн дээд тал нь 21 нас хүртэл нь тэжээн тэтгэхэд шаардагдах нийт зардлыг хуваагдахгүй цэвэр хөрөнгөөс гарган тэжээн тэтгэнэ.

Есдүгээр бүлгийн 1-р зүйлд зааснаар:

Арван найман нас хүрсэн хүн өөрт нь гэрээсэлсэн хөрөнгөө захиран зарцуулж болно. Мөн гэрээслэлийг тухайн хүн нь хүнтэй гэрлэсэн, түүнчлэн арван таван нас хүрсэн, мөн тухайн хүн өөрийн захиран зарцуулдаг хөрөнгөтэй холбоотой тохиолдолд тухайн хүнээр гэрээслэлийг хийлгэж болно.

Товч дүгнэлт

- Бидний судалгаанд хамрагдсан улс орнуудын гэр бүлийн хууль, иргэний хуульд ихэнх төлөв эцэг, эх болон хүүхдийн өмчийг тусгаарлан авч үзэх зарчим барьдаг болох нь харагдаж байна.
- Насанд хүрээгүй хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудлаарх эх, эцгийн эрх, үүрэг, хүүхдийн эд хөрөнгө, өмчийг эцэг эх, асран хамгаалагч захиран зарцуулах эрх, энэхүү эрх дуусгавар болох нөхцөл зэрэг асуудлыг нэлээд нарийвчлан зохицуулсан байна.
- Гэр бүл цуцлуулах үед дундаасаа хүүхэдтэй бол хүүхдийн амьдрах таатай орчин, боловсролын асуудал, сэтгэл санааны болон аюулгүй байдлын талаарх бүхий л асуудлыг хүүхдэд таатай байдлаар бүрэн шийдвэрлэхийг шаардахаас гадна хүүхдийн амьжиргааны зардалд зориулсан тэтгэмжийг эцэг эхийн хэн нэгнээс гаргуулдаг.
- Гэр бүл цуцлалтын үед гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваахад хүүхдэд ногдох хувь хэмжээ гэж байдаггүй. Гэр бүлд хамтран олсон бүх хөрөнгийг гэр бүл цуцлахад эхнэр, нөхөр тэнцүү хуваан авах боловч шүүхээс хүүхдийн эрх ашгийг харгалзан хүүхдээ өөр дээрээ авч үлдэж буй эх юмуу эцэгт дундын эд хөрөнгөөс илүү хувь ноогдуулдаг.
- Зарим улсад тухайлбал, Канад улсад хэрвээ хэн нэгэн гэрлэлтээ цуцлуулахаар шийдвэл хүүхдээ өсгөх, асран хүмүүжүүлэх төлөвлөгөө гаргах, өөрийн санхүүгийн байдал, бүх эд хөрөнгийн жагсаалт, өр зээл, орлого ба зарлагын мэдээллүүдийг тодорхой болгож бэлтгэсэн байх ёстой байдаг нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хариуцлагаа ухамсарлан хүүхдийн эрх ашгийг нэн түрүүнд тавих шаардлагын илэрхийлэл гэж үзэж болно.
- Өв залгамжлах асуудлын тухайд гэрээслэлийн дагуу өвлөх болон хуулийн дагуу өвлөх гэсэн өвлөлийн хоёр хэлбэр байна. Өвлөлийн хэлбэрийн нэгдүгээрт гэрээслэлийн дагуух өвлөлийг нэрлэх боловч өвлөгчдийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай үед өвлүүлэгчийн хүсэлт болох гэрээслэлийн заалтуудыг хязгаарлах хуулийн зааглалтууд бас байдаг.
- Ихэнх улсад хууль тогтоомжоор хуулийн дагуу өвлөгчдийг эрэмбэлэн дараалал тогтоож байгаа ба өв үлдээгчийн хүүхдүүд, үүнд үрчилж авсан болон нас барсны нь дараа төрсөн хүүхдүүд мөн орж байгаа ба тэд өв залгамжлагчдын эхний ээлжинд орж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Семейный кодекс Украины. [www. meget.kiev.ua](http://www.meget.kiev.ua)
2. Гражданский кодекс Украины. [www. meget.kiev.ua](http://www.meget.kiev.ua)
3. Закон Украины "О нотариате". [www. pravoved.in.ua](http://www.pravoved.in.ua)
4. Гражданский кодекс Литовской Республики. <http://www3.lrs.lt>
5. CHILDREN'S LAW ACT OF CANADA. <http://www.lawsociety.ab.ca/>
6. CIVIL CODE OF QUÉBEC PRELIMINARY PROVISION. <http://www.lawsociety.ab.ca/>
7. DIVORCE ACT R.S.C., 1985, C. 3 /CANADA/. <http://www.lexadin.nl/>
8. FAMILY LAW ACT CHAPTER F-4.5 /CANADA/. <http://www.lexadin.nl/>
9. MARRIAGE CODE (SWEDISH CODE OF STATUTES 1987:230). <http://www.government.se/>
10. ACT ON THE CHILDREN AND PARENTS CODE SWEDISH CODE OF STATUTES SFS 1949:381. <http://www.international-divorce.com/>
11. INHERITANCE CODE (REPRINTED IN SWEDISH CODE OF STATUTES 1981:359). <http://www.international-divorce.com/>
12. Бүгд Найрамдах Хятад Ард улсын Гэрлэлтийн тухай хууль, 1980 ” БНХАУ-ын хууль /中华人民共和国婚姻法/ <http://www.people.com.cn/>
13. Бүгд Найрамдах Хятад Ард улсын Иргэний хууль, 1986, БНХАУ-ын хууль /中华人民共和国民法通则/ <http://law.lawtime.cn/>
14. Бүгд Найрамдах Хятад Ард улсын Өв залгамжлах тухай хууль, 1985, БНХАУ-ын хууль /中华人民共和国继承法/ <http://www.lawtime.cn/zhishi/>
15. Гэрлэлтийн процедур ба хөрөнгийн тухай журам, 1972, Хон Конгийн хууль /CAP 192 Matrimonial Proceedings and Property Ordinance [1972]/ <http://www.hkliv.hk/>
16. Гэрлэлтийн тухай хууль (234/1929), Финланд улсын хууль /Marriage Act (234/1929)/ <http://www.finlex.fi/>
17. Өв залгамжлах тухай хууль (40/1965), Финланд улсын хууль /Code of Inheritance (40/1965)/ <http://www.finlex.fi/>